


“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН  
КОДЕКС”-ИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

*“Монголын хөрөнгийн бирж” ХК*

Улаанбаатар

2023 он



## ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Энэхүү үнэлгээний аргачлалын дагуу “Монголын хөрөнгийн бирж”ХК (цаашид МХБ ТӨХК гэх)-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хийж гүйцэтгэсэн бөгөөд үр дүнг ТУЗ-ийн дарга хянаж баталсан болно.

### Үнэлгээний бүтэц

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний загвар нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

1. ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт
2. ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг
3. Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал
4. Аудит, хяналтын тогтолцоо
5. Эрсдэлийн удирдлага
6. Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал
7. Оролцогч талуудын эрх ашиг
8. Компанийн соёл
9. Хувьцаа эзэмшигчдийн эрх

### Үнэлгээний аргачлал

Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан 2, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан 1, үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлсэн ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулав.

Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ:

- авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
- 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
- 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

## ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12		100%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10		100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6		100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6		100%
5	Эрсдэлийн удирдлага	8	8		100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6		100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	6		75%
8	Компанийн соёл	6	6		100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9		90%
	<b>Нэгдсэн дүн</b>	<b>72</b>	<b>69</b>		<b>96%</b>

*/Хүснэгт 1. Монголын хөрөнгийн бирж ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээний нэгдсэн дүн/*

**ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

<b>Компанийн засаглалын үнэлгээний асуулга</b>					
<i>Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..</i>					
<b>НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b>					
<b>ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна</b>					
<b>№</b>	<b>Зүйл</b>	<b>Хэрэгжилт</b>	<b>Тайлбар</b>	<b>Оноо</b>	<b>Хувь</b>
1	<i>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 2010 оны 9-р сарын 10-ны өдөр батлагдаж 2013 оны 5-р сарын 10-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-д ТУЗ-ийн дарга, гишүүд, НБД-ын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгасан байдаг.	2	100%
2	<i>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам болон Хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах журамд ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага, нэр дэвшүүлэх зэрэг харилцааг нарийвчлан зохицуулсан бөгөөд ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 35 дугаар тогтоолын Гуравдугаар хавсралтаар “Залгамж халааны бодлогын”-ын төслийг агуулгын хувьд сайшаан баталсан бөгөөд 2023 оны 9 дүгээр сард батлахаар ажиллаж байна.	2	100%
3	<i>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Бирж нь төрийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компани тул Компанийн тухай	2	100%

	<p>зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.</p>	<p>хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль болон ТУЗ-ийн гишүүн сонгохтой холбоотой харилцааг зохицуулсан засгийн газрын журмын хүрээнд ТУЗ-ийн гишүүдэд тавигдах шаардлагыг тодорхойлж, нээлттэй сонгон шалгаруулж тэдгээрийн хувийн мэдээлэл болон ТУЗ-ийн ирц зэргийг хувьцаа эзэмшигчийн ээлжит хуралд танилцуулдаг. Мөн компанийн цахим хуудсанд ТУЗ-ийн гишүүд болон тэдгээрийн ирцийн мэдээлэл, гаргасан шийдвэр зэрэг нь олон нийтэд нээлттэй байдлаар тавигддаг.</p>		
4	<p>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршилагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.</p>	<p>Бүрэн хэгжүүлсэн</p> <p>Компанийн дүрэм болон ТУЗ-ийн ажиллах журам, хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах журамд хороодын бүтэц, бүрэлдэхүүн болон хараат бус гишүүнд тавигдах шаардлага зэрэг асуудлууд тусгагдсан байдаг. Түүнчилэн ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 35 дугаар тогтоолын Хоёрдугаар хавсралтаар “Төлөөлөн удирдах</p>	2	100%

			зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын төслийг сайшаан баталсан бөгөөд 2023 оны 9 дүгээр сард багтаан ТУЗ-ийн хурлаар батлахаар ажиллаж байна.		
5	<i>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн гишүүдийг анх томилогдоход компанийн үйл ажиллагаа болон ТУЗ-ийн үйл ажиллагаатай танилцуулах сургалт хийдэг. Цаашид энэ талаарх харилцааг зохицуулсан эрх зүйн актын төслийг боловсруулж батлуулан ажиллах болно.	2	100%
6	<i>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ТУЗ-ийн дарга томилдог бөгөөд түүний шууд удирдлага дор чиг үүргээ хэрэгжүүлдэг бөгөөд ТУЗ-ийн ажлын албаны чиг үүргийг бүрэн хариуцан хэрэгжүүлдэг.	2	100%
<b>ДҮН</b>				12	100%
<b>ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ</b>					
<b>ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ</b>					
7	<i>2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 7.1-д “Биржийн төлөөлөн удирдах зөвлөл есөн гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн дөрөв нь хараат бус гишүүн байна” гэж заасны дагуу 2023 оны 06 дугаар сарын 30-ны	2	100%

			өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар ТУЗ-ийн ердийн 5, хараат бус 4 гишүүнийг сонгосон.		
8	<i>2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэм болон ТУЗ-ийн ажиллах журмаар Аудитын хорооны үйл ажиллагааг зохицуулдаг ба Аудитын хорооны дарга нь хараат бус гишүүн байдаг. Мөн Аудитын хорооны хуралд Гүйцэтгэх захирал болон бусад захирлууд Аудитын хорооны хүсэлтээр оролцдог.	2	100%
9	<i>2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Биржийн 2014 оны 5 дугаар сарын 9-ний өдөр батлагдсан цалин урамшууллын хорооны дүрмээр ажилтны цалин урамшууллын бодлогыг хэрэгжүүлдэг. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны дарга нь хараат бус гишүүн байдаг ба тус хорооны хуралд Гүйцэтгэх удирдлага болон бусад захирлууд хорооны хүсэлтээр оролцдог	2	100%
10	<i>2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Биржийн 2014 оны 6 сарын 23-ны өдөр батлагдсан ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах, томилох журам нь ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны чиг үүргийн ихэнх хэсгийг	2	100%

			зохицуулдаг. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байдаг.		
11	<i>2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрмээр ТУЗ нь дэргэдээ Аудит, Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх, Эрсдэлийн удирдлагын гэсэн 4 хороотой ажиллаж байна. Хороодын үйл ажиллагааг Компанийн дүрэм болон ТУЗ-ийн ажиллах журмаар зохицуулдаг. Мөн хорооны гишүүдийн 2/3 нь хараат бус гишүүн байхаар зохицуулсан байдаг.	2	100%
ДҮН				10	100%
<b>ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ</b> ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					
12	<i>3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн 2003 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 11 дугаар тогтоолоор баталсан “Мэдээллийн журам”-ийн дагуу мэдээллийн ил тод байдал болон тайлагнал, түүнд тавих хяналт зэргийг зохицуулсан байгаа.	2	100%
13	<i>3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн албан ёсны цахим хуудас болох <a href="http://www.mse.mn">www.mse.mn</a> хаягаар хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчдад зориулан ТУЗ-ийн мэдээлэл, компанийн санхүү, үйл ажиллагаа, болон засаглалтай холбоотой мэдээ, мэдээллүүд (Санхүүгийн тайлан, үйл ажиллагааны	2	100%



		тайлан, засаглалын дүрэм журмууд болон үйл ажиллагаатай холбоотой онцлох мэдээ мэдээллүүд ) тогтмол шинэчлэгдэн тавигддаг.		
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Бүрэн хэрэгжүүлсэн Монголын хөрөнгийг бирж нь үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангаа жил бүр сайжруулан ажилладаг. Бид компанийн үндсэн үйл ажиллагаа, стратеги төлөвлөгөөнд нөлөөлөхүйц үйл явдлуудыг ойлгомжтой байдлаар хураангуйлан оруулдаг ба хөндлөнгийн аудитын дүгнэлт, тодруулгыг бүрэн эхээр нь хавсарган оруулдаг. Санхүүгийн бус тайлангийн хувьд компанийн үйл ажиллагааны үр дүн, байгаль орчин, нийгмийн хариуцлага, засаглал, ТУЗ-ийн үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, тогтвортой хөгжил зэрэг агуулгаар мэдээлэл бэлтгэн оруулдаг.	2	100%
ДҮН			6	100%
<b>ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО</b>				
<b>ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана</b>				
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн Компанийн дүрэм болон ТУЗ-ийн ажиллах журамд Аудитын хороо нь хөндлөнгийн аудитын компанийг сонгох болон түүний ажлын	2	100%

			даалгавар, тайлан, дүгнэлтийг ТУЗ-д танилцуулж шийдвэрлэдэг.		
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Хөндлөнгийн аудитын гаргасан дүгнэлтийг тодруулгын хамт эх хувиар нь хувьцаа эзэмшигчийн ээлжит хуралд компанийн удирдлагууд танилцуулдаг.	2	100%
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Дотоод аудитын бүтэц, чиг үүргийн талаар Компанийн дүрэмд тусгагдсан байдаг бөгөөд компанийн цахим хуудаст Дотоод аудитын бүтэц болон гишүүдийн мэдээлэл байршдаг.	2	100%
ДҮН				6	100%
<b>ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА</b>					
ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина					
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 29 дүгээр тогтоолын Гуравдугаар хавсралтаар “Эрсдэлийн удирдлагын бодлого” баталсан. ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хороо нь тус бодлогын дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлж ТУЗ-д танилцуулж ажиллаж байна.	2	100%
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны	Бүрэн хэрэгжүүлсэн	Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит хурлаар компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталж, улсын бүртгэлд бүртгүүлсэн. Тус дүрэмд заасаар ТУЗ нь дэргэдээ	2	100%

	<i>хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.</i>		эрсдэлийн удирдлагын хороотой байхаар зохицуулсан бөгөөд ТУЗ-ийн 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар эрсдэлийн удирдлагын хорооны гишүүдийг томилсон.		
20	<i>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн Эрсдэлийн удирдлагын бодлогын дагуу эрсдэлийн мэргэжилтэн энэ талаар мэдээлэл боловсруулан Гүйцэтгэх удирдлагаар дамжуулан ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд тайлагнаж ажилладаг.	2	100%
21	<i>5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэмд эрсдэл /комплайнс/-ийн удирдлагын хороо нь комплайсыг давхар хариуцан ажиллаж байгаа. Түүнчилэн комплайнсын ажилтантай бөгөөд хороо нь ТУЗ-д энэ талаар тайлагнаж ажилладаг.	2	100%
<b>ДҮН</b>				8	100%
<b>ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ</b> Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					
22	<i>6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэмд зааснаар ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал, давтамж зэргийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж баталдаг бөгөөд төрийн өмчийн оролцоотой компанийн хувьд Төрийн өмчийн бодлогын	2	100%

			зохицуулалтын газрын чиглэлийн дагуу ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроор үржүүлснээс ихгүй байхаар тогтоосон.		
23	<i>6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Хөдөлмөрийн дотоод журмын шинэчилсэн найруулга болон цалин урамшууллын хорооны дүрэмд ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур, ажил үүргийн бүрдэл хэсэг зэргийг тусгасан байдаг. Түүнчилэн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх журмыг 2023 онд батлан хэрэгжүүлж ажиллаж байна.	2	100%
24	<i>6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Бирж нь 66% төрийн өмчийн оролцоотой нээлтгэй хувьцаат компани бөгөөд Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэл буюу гэрээний биелэлтийг Төрийн өмчийн хорооны 2010 оны 166 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг тэнцвэржүүлсэн үнэлгээний аргаар дүгнэх, урамшуулал олгох журамд заасны дагуу төрийн өмчийн хороо батлагдсан	2	100%

			аргачлалын дагуу шалгаж, хувьцаа эзэмшигчийн ээлжит хурлаар танилцуулдаг.		
ДҮН				6	100%
<b>ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ</b>					
<b>Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ</b>					
25	<i>7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэм болон Гүйцэтгэх удирдлагын “Хөлсөөр ажиллах гэрээ”-нд энэ талаар нарийвчлан зохицуулсан байдаг боловч бодлогын баримт бичиг бүрэн биш.	1	50%
26	<i>7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Компанийн үйл ажиллагааны тайланд энэ талаар тусгаж Хувьцаа эзэмшигчийн ээлжит хурлаар танилцуулдаг. Цаашид энэ талаар үйл ажиллагааны тайланд тусгана.	1	50%
27	<i>7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн цахим хуудас нь идэвх, хөгжүүлэлт сайтай бөгөөд оролцогч талуудад мэдээллийг цаг алдалгүй хүрэгдэг.	2	100%
28	<i>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх Хөдөлмөрийн дотоод журмаар нарийвчлан зохицуулсан. Харин ажилтнуудын нийгмийн асуудал болон мэргэжил дээшлүүлэх талаар компанийн Хүний нөөцийн бодлогын баримт бичиг болон дотоод журмуудаар зохицуулсан байдаг.	2	100%
ДҮН				6	75%
<b>НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ</b>					
ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					

29	<p><b>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</b></p>	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Компанийн 2013 оны 10 дугаар сарын 15-нд батлагдсан “Ажилтны ёс зүйн дүрэм”, 2016 оны 8 дугаар сарын 8-ны өдөр батлагдсан “Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах ёс зүйн зөрчлийг хянан шалгах журам”-уудаар компанийн нийт ажилчдын ёс зүйн асуудлыг зохицуулж, хяналт тавьж ажилладаг ба дээр журмууд нь компанийн албан ёсны цахим хуудсанд байршсан байдаг.</p>	2	100%
30	<p><b>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.</b></p>	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Биржийн “Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шалгах журам”-аар ёс зүйн хороо, түүний бүтэц бүрэлдэхүүн, чиг үүрэг зэргийг зохицуулж өгсөн ба Хөдөлмөрийн дотоод журмаар “шүгэл үлээгчийн” талаар нарийвчлан зохицуулсан байдаг. Түүнчилэн ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 35 дугаар тогтоолын Зуравдугаар хавсралтаар “Сонирхлын зөрчлийг зохицуулах журам”, Долдугаар хавсралтаар “Шүгэл үлээх журам”-ын төслийг агуулгын хувьд сайшаан баталсан. Тус журмуудыг 2023 оны 9 дүгээр сард багтаан</p>	2	100%

			батлуулахаар ажиллаж байна.		
31	<i>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 35 дугаар тогтоолын Зуравдугаар хавсралтаар “Сонирхлын зөрчлийг зохицуулах журам”-ын төслийг агуулын хувьд сайшаан баталсан, ТУЗ-ийн 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 29 дүгээр тогтоолын Хоёрдугаар хавсралтаар “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр”-ийг Хоёрдугаар хавсралтаар баталсан. Түүнчлэн “Ажилтны ёс зүйн дүрэм”-ийг мөрдүүлж ажиллаж байна.	2	100%
ДҮН				6	100%
<b>ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ</b>					
<b>Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана</b>					
32	<i>9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.</i>	Бүрэн хэрэгжүүлдэг	Компанийн албан ёсны цахим хуудас болох <a href="http://www.mse.mn">www.mse.mn</a> , болон Монголын хуудсаар компанийн ТУЗ-ийн мэдээлэл, үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн мэдээлэл, компанийн үйл ажиллагааны талаар онцлох мэдээ, мэдээлэл	2	100%
33	<i>9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.</i>	Хэсэгчилэн хэрэгжүүлсэн	Компанийн албан ёсны цахим хуудас болох <a href="http://www.mse.mn">www.mse.mn</a> хуудаст жилийн хөрөнгө оруулалтын	1	50%

			төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийн талаарх мэдээллийг тухай бүрт оруулж ажилладаг.		
34	<i>9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 35 дугаар тогтоолын Тавдугаар хавсралтаар “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын төслийг агуулгын хувьд сайшаан баталсан. Түүнчилэн бирж нь төрийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компани бөгөөд компанийн 66 хувийн хувьцааг төр эзэмшдэг ба хувьцаа эзэмшигчийн эрхийг Сангийн яам хэрэгжүүлдэг. Мөн ТУЗ-ын зарим гишүүд нь Төрийн төлөөлөл бөгөөд Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх нөхцөл бололцоо бүрэн бүрдсэн.	2	100%
35	<i>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Бирж нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах хяналтын зөвлөлтэй бөгөөд тус зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн санал гомдлыг хүлээн авч холбогдох арга хэмжээ авдаг.	2	100%
36	<i>9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 35 дугаар тогтоолын Зуравдугаар хавсралтаар “Сонирхлын зөрчлийг	2	100%



		зохицуулах журам"-ыг агуулгын хувьд сайшаан баталсан бөгөөд ТУЗ-ийн 9 сарын ээлжит хурлаар батлуулахаар ажиллаж байна.		
ДҮН			9	90%
<b>НЭГДСЭН ДҮН</b>			<b>69</b>	<b>96%</b>

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Г.Тэмүүжин

ТАЙЛАНГ ХЯНАЖ БАТАЛСАН:

ТУЗ-ийн дарга



Д.Тогтохбаяр

2022 оны 07-р сарын 07-ны өдөр

